



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2005 оны 3 сарын 21 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

**Дүрэм батлах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль хамгаалах газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Байгаль хамгаалах газар /Г.Бүдрагчаа/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2003 оны 99 дүгээр захирамжийн 4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ**

**М.ЭНХБОЛД**



## НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ГАЗРЫН ДҮРЭМ

### Ш.г. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль хамгаалах газар нь /цаалид "газар" гэх/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, ноход сэргээх, экологийн тэнцлийг хангах талаар явуулж байгаа горийн бодлого, шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэр, Улаанбаатар хотын ногоон бүсэд хэрэгжүүлэх үүрэг, зорилго бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай, Байгаль орчны багц хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, төрөөс байгаль орчны талаар баримтлах бодлого, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бодлого, тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.4. Нийслэлийн Засаг дарга нь газрын орон тооны хязгаарыг тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр дэд даргыг томилж, чөлөөлнө.

1.6. Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажиллагсдыг томилж, чөлөөлнө.

1.7. Газар нь үүрэг зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар газрын даргад зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

1.8. Газрын дарга нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлэн төсвийг зарцуулна.

1.9. Газрын дарга нь газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гарсан хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага болон Засгийн газрын холбогдох харьяа агентлаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу үр дүнгийн тэрээ байгуулж, бүтээгдэхүүн нийлүүдэх зарчмаар зохион байгуулна.

1.10. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба банкинд хариуцах данстай байна.

### **Хоёр. Газрын үүрэг**

2.1. Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнах.

2.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт экологийн гэнцлийг хангах, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах бодлого боловсруулахад оролцох.

2.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг хариуцах.

2.5. Нийслэлийн ноогон бүсийн байгалийн ноог баялаг ашигласны төлбөр хураамж, үнэлгээг шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулан батлуулж мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах ажлалах.

2.6. Нийслэл хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, дагуул хотуудын төлөвлөлт, байршилт, шинээр байгуулах болон өргөтгөн шинэчлэх, тоноглох үйлдвэр аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн зургийн даалгавар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд экологийн магадлан шинжилгээ гаргуулж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангуулах.

2.7. Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн ноог баялаг ашиглах алшаа төсөл, арга хэмжээг байгаль орчинд нолодох байдлын үнэлгээнд хамруулах.

2.8. Улаанбаатар хотын ногоон бүсийн байгаль орчин, экологийн төлөн байдлыг тодорхойлох, байгалийн баялгийн ноогийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй хөтөлбөр, төлөвлөгөө, төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөл, Байгаль орчны сайдын зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.9. Хотын ногоон бүсийн байгалийн баялаг / ашигт малтмал, ан амьтан, ургамал, хөрс, ой мод, газар, ус гэх мэт / болон орчныг бохирдуулах эх үүсвэрийн тооллого, бүртгэл судалгаа гаргах.

2.10. Цадраг идэвхит болон химийн бусад хортой бодис, нефть, хий, үйлдвэрлэлийн хаягдлыг тусгайлан хадгалах, булахад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх.

2.11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх улсын даалгавар, захиалгат ажлын биелэлтийг хангуулж гүйцэтгэлийг тогтоосон журмаар гаргуулах.

2.12. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах. Ой, ус, хөрс, ургамал, ан амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад зориулсан хялбарчилсан гарын авлага, зөвлөмж боловсруулан нийтийн хүртээл болгох.

2.13. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч тэдний оролцоог өргөжүүлэх.

2.14. Холбогдох хууль тогтоомж, газрын дотоод журмын дагуу ажиллагсдад нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх талаар шат дараатсан арга хэмжээ авч ажиллах.

2.15. Эрхэлж буй ажлын хүрээнд хамаарах зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

2.16. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээр хянуулах.

2.17. Газрын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, омч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.



## Гурав. Газрын эрх

3.1. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдээс байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд зохих журмын дагуу арга хэмжээ авах.

3.2. Экологийн хувьд зөвшөөрч болохгүй үйлдвэр, цех, аж ахуйн нэгжийг шинээр байгуулахад хорш тавих.

3.3. Байгаль орчин, экологийн төлөв байдлыг үнэлэх, хамгаалах, тодорхой асуудлаар магадлагаа гаргахад шаардагдах мэдээ баримт, судалгааг холбогдох байгууллага хүмүүсээс гаргуулж авах.

3.4. Хот, дүүргийн төр захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан тогтоол, тушаал, захирамж, заавар, журам, аргачлал, техник технологийн шийдэл нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжилд нийцэхгүй, байгальд сөрөг нөлөө үзүүлэхээр байвал түүний заалтыг хүчингүй болгуулах буюу өөрчлүүлэх тухай шаардах, дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3.5. Хотын нутаг дэвсгэр, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, экологийн тэнцлийг хадгалах талаар санал дүгнэлтээ Байгаль орчны яам, Нийслэлийн Засаг даргад тавих.

3.6. Байгалийн нөөц ашигласныг төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хоронгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, улмаар баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх төсөлд, арга хэмжээг сонгон шаангаруулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

3.7. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.8. Байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах асуудлыг Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх, гэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

3.9. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.

## Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1. Газрын дарга, дэд дарга, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүрэг хангалтгүй биелүүдсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

**Тав. Бусад зүйл**

5.1. Энэхүү дүрмэнд нийслэлийн Засаг даргын захиамжаар нэмэлт оорчлолт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

5.2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын  
2005 оны 3 сарын 27 ны өдрийн  
97 (дугаар дүгээр) Захирамжийн  
хоёрдугаар хавсралт

## Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө

### Нэг. Нийтлэг үндэслэл

#### 1.1. Оршил.

Нийслэлийн Байгаль хамгаалах газрын бизнес төлөвлөгөөгөөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн, Нийслэлийн Байгаль хамгаалах газрын даргын шийдвэрийг боловсруулахад оролцох, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн төлөвлөлт бодлогын удирдамж, орон нутгийн төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах асуудлыг хамарсан Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны загварыг тодорхойлов.

#### 1.2. Үндэслэл

Бизнес төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 15 дугаар тогтоол, "Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дүрэм" болон бусад холбогдох баримт бичгийг үндэслэл боловсруулав.

#### 1.3. Хууль тогтоомжийн оршил.

Бизнес төлөвлөгөөг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

– Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль.

– Монгол Улсын Төрийн албаны тухай хууль.

– Монгол Улсын Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль.

– Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хууль.


– Монгол Улсын Байгаль Орчны тухай багц хууль болон бусад хууль тогтоомж.

### 1.4. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь.

Нийслэлийн Байгаль хамгаалах газар нь Нийслэлийн Засаг даргын морийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар үүрэг хүлээж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нохон сэргээх ажлыг удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

### 1.5. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Байгаль орчин, экологийн байдалд хяналт тавих стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус байгууллагын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.



Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үндсэн үйлчүүлэгч буюу хэрэглэгч нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дарга байна.

Нийслэлийн Байгаль хамгаалах газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг



хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, төрийн албан хаагчдын ажлын байрны годорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## **Хоёр. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны стратеги**

### **2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар**

Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дүрмээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн Нийслэлийн Байгаль хамгаалах газрын даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл.**

Нийслэлийн Байгаль хамгаалах газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана.

1. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх.
2. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт үзүүлэх зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэгийн үр дүнг сайжруулах.

### **2.3. Эрхэм зорилго.**

Монгол Улсын нийслэлийн хэмжээнд байгалийн баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажлыг шинжлэх ухааны үндэстэйгээр зохион байгуулах замаар нийслэлийн байгаль орчин, экологийн тэнцвэртэй байдлыг хангах.

### **2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилго.**

Нийслэлийн Байгаль хамгаалах газар нь эрхэм зорилгоныхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилгыг хэрэгжүүлнэ.

1. Байгаль орчны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хууль зөрчигчдийг илрүүлэх, зохих арга хэмжээ авч таслан зогсоох.
2. Байгаль орчныг зүй зохистой ашиглах үйл ажиллагааг зохион байгуулах.
3. Байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах.
4. Байгаль орчны төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгөх.
5. Хот байгуулалт, тодовлолтод байгаль орчны чиглэлээр оролцох.

## 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Нийслэлийн Байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд эдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиглана.

### 1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилгын хүрээнд:

- 1.1. Байгаль хамгаалагчид, мэргэжилтнүүдийн мэдлэг, ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэн чадваржуулах.
- 1.2. Байгаль хамгаалагчид, мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөл бололцоог хангах.
- 1.3. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар хяналтын механизмыг хүчтэй болгох.
- 1.4. Байгаль орчныг хамгаалах талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах.
- 1.5. Хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, холбогдох байгууллагад тавих.

### 2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилгын хүрээнд:

- 2.1. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаар ард иргэдэд мэдлэг олгох.
- 2.2. Байгалийн баялаг ашиглалтанд хяналт тавих.
- 2.3. Ашиглах байгалийн баялгийн нэр, төрөл, тоо хэмжээ, байршил тогтоон огч байх.
- 2.4. Байгалийн баялаг ашигласны төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн боловсруулж батлуулан мөрдөн ажиллах.
- 2.5. Өөрийн эрх, үүргийн хүрээнд байгалийн зарим баялгийг ашиглах зөвшөөрлийг зохих журмын дагуу олгох.

### 3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилгын хүрээнд:

- 3.1. Нөхөн сэргээх ажлын нэр, төрөл, тоо хэмжээ, байршил тогтоож байх.
- 3.2. Нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх байгууллага, аж ахуйн нэгжийг зөв сонгох, түүнд зарцуулах хөрөнгийг шийдвэрлүүлэх.
- 3.3. Нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих, хүлээн авах.

### 4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилгын хүрээнд:

- 4.1. Аливаа төсөл арга хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт гаргах.
- 4.2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөнд байгаль орчны чиглэлээр тусгагдсан ажлууд,

хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдэд санал огч, бусад салбаруудтай нягт уялдуулах.

4.3. Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэн ажиллах.

4.4. Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр хийгдсэн "Хогын хөгжлийн стратеги" бодлогын баримт бичигт тулгуурлан түүнд тусгагдсан байгаль орчны зорилтуудыг ханган биелүүлэх.